

“IFPIM МОНГОЛ” ХӨТӨЛБӨР

2024

НӨЛӨӨЛЛИЙН

ТАЙЛАН



Агуулгын жагсаалт

ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ	3
“IFRIM МОНГОЛ” ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ	4
ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД	5
НӨЛӨӨЛӨЛ	7
НӨЛӨӨЛӨЛ: БАЙГУУЛЛАГЫН ТҮВШИНД	8
НӨЛӨӨЛӨЛ: РЕДАКЦЫН ТҮВШИНД	11
НӨЛӨӨЛӨЛ: НИЙГМИЙН ХЭМЖЭЭНД	13


НӨЛӨӨЛЛИЙН Хураангуй

ОНЦЛОХ ҮР ДҮН ЮУ БАЙВ?

6 хэвлэл мэдээллийн байгууллага нийт 218 санаачилгыг хөтөлбөрийн 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөв.


Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахын тулд бид нийт 63 хэмжүүрийг тогтмол хянаж байна.

ГҮЙЦЭТГЭЛ



2024 онд нийт 218 санаачилгын 79 нь хэрэгжиж дууссан байна.

ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙН ХУВААРИЛАЛТ (%)



ЭДИЙН ЗАСГИЙН ХАТ



Оролцогч байгууллагуудын Эдийн засгийн хатын дундаж (Боломжит 5 онооноос)

ӨСӨЛТ

+46%

1 жилийн дараах орлогын дундаж өсөлт (тэтгэлгийг оруулалгүйгээр)

+22%

1 жилийн дараах хандалтын дундаж өсөлт (сошиал медиа дээрх)


+27%

1 жилийн дараах хүний нөөцийн тэлэлт


ГОЛ ТӨВЛӨРӨЛ (2024)

- Санхүүгийн бэрхшээл
 - Орлогын цөөн суваг
 - Хүний нөөцийн эргэц
- Тоног төхөөрөмжийн дутмаг байдал
- Стратеги төлөвлөлт, өрсөлдөх чадвар

ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОГЧ РЕДАКЦУУДЫН УНШИГЧДЫН ХҮН АМ ЗҮЙ




Нийт уншигчдын 56% нь эмэгтэй



Нийт уншигчдын 47% нь 35-аас доош насны

“IFPIM МОНГОЛ” Тухай

ХӨТӨЛБӨРИЙН ХӨДӨЛГҮҮР



Монгол Улсад бие даасан сэтгүүл зүйн тогтвортой байдлыг хамгаалж, бэхжүүлэх зорилгоор **Сэтгүүл зүйн Инновац, Хөгжлийн Үүр Төв** нь **Нийтийн эрх ашгийн төлөөх хэвлэл мэдээллийг дэмжих олон улсын сан (IFPIM)** болон **Financial Times Strategies (FTS)** компанитай хамтран Монголын хэвлэл мэдээллийн салбарыг дэмжих түншлэлийг байгууллаа.

2023 оны сүүлчээр редакцын стандарт, үзэгчдийн олон талт байдал зэргээрээ шалгарсан **зургаан хэвлэл мэдээллийн байгууллага** сонгогдож, **гурван жилийн хугацаатай хөтөлбөрт** нэгдэв. Энэхүү хөтөлбөр нь **нийтийн эрх ашгийн төлөөх сэтгүүл зүйг** хөгжүүлэхэд шаардлагатай стратеги, бизнесийн хөшүүргийг бий болгох замаар оролцогч байгууллагуудад **санхүүгийн болон стратегийн дэмжлэг** үзүүлж байна.

Сонгогдсон хэвлэл мэдээллийн байгууллагууд Үүр Төв, IFPIM болон FTS-ээс гурван жилийн хугацаанд санхүү, хөгжлийн дэмжлэг авч, стратегийн зорилтууддаа нийцүүлэн төлөвлөгөөт санаачилгуудаа хэрэгжүүлэх юм.

Бүх оролцогч байгууллагууд Сэтгүүл зүйн Инновац, Хөгжлийн Үүр төв болон FTS-ийн хамтран зохион байгуулсан **стратеги төлөвлөгөө боловсруулах дөрвөн өдрийн сургалтад** оролцож, урт хугацааны стратегия тодорхойлж, гол зорилтот чиглэлүүдээ тодорхойлсон.

if International Fund
for Public Interest Media



FT STRATEGIES

ОРОЛЦОГЧИД

ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮТЭЭГЧИД



Graph.mn

Үүсгэн байгуулагдсан 2021.01.28

Мэдээ, мэдээллийг нүд булаам хийц, хүртээмжтэй хэлбэрээр түгээгч дижитал суваг



iToim.mn

Үүсгэн байгуулагдсан 2015.01.26

Аналитик, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онлайн платформ



Lemon Press

Үүсгэн байгуулагдсан 2020.09.22

Санхүү, эдийн засгийн мэдээллийн түүхээ, хамгийн уншигчтай мэйл товхимолтой редакц



NTV Телевиз

Үүсгэн байгуулагдсан 2006.11.01

“Бүгдийг бус чухлыг нь” уриатай, Монголын хамгийн олон үзэгчтэй сувгуудын нэг



UB.Life

Үүсгэн байгуулагдсан 2016.02.07

Залууст зориулсан дижитал мэдээ, мэдээллийн платформ



Зууны Мэдээ сонин

Үүсгэн байгуулагдсан 1999.01.05

Монголын хоёр дахь ууган өдөр тутмын сонин

ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭЛБЭР

Дижитал

Телевиз


Сонин

“АЛТАН ГАДАС” СТРАТЕГИЙН
СУРГАЛТ
2023.11.05



Хөтөлбөр: 11-р сарын 6-ны Даваа гараг

10:00	Нээлт	14:00	Алтангадас аргачлалын тухай
10:20	4 өдрийн төлөвлөгөө, хамтран ажиллах зарчмыг	14:45	Байгууллагын 3 жилийн зорилго
11:00	Өнцгийн оноцтой танилцах гэмтээрчилсэн өлчлөг	15:00	Завсарлага
12:15	Өнцгийн оноцтойро танилцах	15:15	Алтангадас зорилго
12:30	Стратегийн сонголтын курс	16:30	Дулилт
13:30	Удрийн хоол		



НӨЛӨӨЛӨЛ

ХЭРХЭН БИЙ БОЛГОЖ БАЙНА ВЭ?

БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛӨӨС НИЙГМИЙН ӨӨРЧЛӨЛТ РҮҮ

Тогтвортой бизнес загвар, урт хугацааны нөлөөлөл бүтээхийн тулд манай оролцогчид **2023 оны 11 сард** Financial Times Strategies (FTS)-ийн чиглүүлгээр **Алтан Гадас Стратегийн хүрээг** ашиглан **гурван жилийн стратегийн төлөвлөгөө**гөө боловсруулав. Төлөвлөгөөг бодит ажил хэрэг болгохын тулд **IFPIM санхүүжилт, FTS сар бүрийн стратегийн зөвлөх үйлчилгээ өгч, NEST зохицуулалт, арга зүйн зөвлөгөө, сургалтаар** хангаж байна. Хөтөлбөрийн хэрэгжүүлэгч тус бүр хөгжлийн шат бүрд чухал оролцоотой.

Бид оролцогчдын үүсгэсэн нөлөөллийг **Байгууллагын, Редакцын, Нийгмийн** гэсэн **гурван харилцан уялдаатай түвшинд** тодорхойллоо. Эдгээр түвшин нь бие биеэ нөхөж, илүү бат бөх, тогтвортой хэвлэл мэдээллийн экосистем бүрдүүлэх замыг бий болгох юм.



БАЙГУУЛЛАГЫН ТҮВШИН ЦӨМИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Өөрчлөлтийг удирдахын тулд оролцогчид **байгууллагаа бэхжүүлэх** зорилтыг нэн тэргүүнд тавьсан. Учир нь **редакцын болон нийгмийн нөлөөлөл бий болгохоос өмнө байгууллагын тогтвортой байдлаа хангах** ёстой. Манай **санхүүжилт** энэхүү өөрчлөлтийн үндэс суурь юм.

Байгууллагын түвшинд **нөлөөллийг хангахын тулд** бид **санхүүгийн тогтвортой байдал, хүний нөөц, стратегийн хэрэгжилт** зэргийг тогтмол хянаж байна. Эдгээр нь оролцогчид зүгээр нэг оршин тогтнохоос илүүтэй Монголын хэвлэл мэдээллийн салбарын өөрчлөлтөд **дасан зохицож, хөгжиж буйг** баталгаажуулна.

РЕДАКЦЫН ТҮВШИН ЧАНАРТАЙ СЭТГҮҮЛ ЗҮЙ

Мэргэжлийн зөвлөгөө, тусгайлсан сургалтаар дамжуулан **редакцын чадавхыг бэхжүүлэхэд** анхаарч байна. Байгууллагууд **гадаад орчны дарамтад тэсвэртэй болсноор уншигчдаа тэлж, контентын чанараа сайжруулан, ёс зүйтэй сэтгүүл зүйг бэхжүүлэх** боломжтой болно.

Редакцын нөлөөлөл бэхжих тусам хэвлэл мэдээллийн хэрэгслүүд олон нийтийн эрх ашгийг хамгаалах, буруутай үйлдлийг ил болгох, тулгамдсан асуудлуудыг анхаарлын төвд авчрах боломж нь нэмэгдэнэ. Ингэснээр нийгмийн нөлөөллийн үндэс суурь тавигдах юм.

НИЙГМИЙН ТҮВШИН ӨӨРЧЛӨЛТӨД ХӨТЛӨХ НЬ



Манай **гол зорилго нийтийн эрх ашгийг төлөөх сэтгүүл зүйг** дэмжиж, **иргэдийг мэдээллээр хангахад** оршино. Оролцогчид төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхдээ **уншигчидтайгаа илүү ойртож, тэдэнд чиглэсэн ажлуудыг хэрэгжүүлж байгаа нь нийгмийн нөлөөллийг** улам нэмэгдүүлж байна.

Байгууллагын тогтвортой байдал, редакцын чанар, уншигчдын оролцоог хослуулснаар **Монголд илүү тогтвортой, хаттай хэвлэл мэдээллийн байгууллагууд олширч,** уншигчдаа мэдээллээр хангаж, олон нийтийг тэтгэх боломжтой.

НӨЛӨӨЛӨЛ Байгууллагад

ЦӨМИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

ОРЛОГЫН БҮТЦИЙН ШИЛЖИЛТ (%) - 2023 БА 2024 - ОРОЛЦОГЧДЫН ДУНДАЖ
(ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ОРУУЛАХГҮЙГЭЭР)
(2024 ОНД НИЙТ ОРЛОГО 46% ӨССӨН)



2024 онд **нийт оролцогчдын хэмжээнд ажиглагдсан орлогын бүтцийн шилжилт нь IFPIM Монгол хөтөлбөрийн стратегийн нөлөөллийг илтгэж байна.**

- Хувийн хэвшлээс олох орлогын эзлэх хувь **24%-**иар өссөн
- Төрөөс хамаарах орлогын эзлэх хувь буурсан нь оролцогчдын санхүүгийн бие даасан байдал сайжирсныг илэрхийлж байна.
- Хэвлэмэл бүтээгдэхүүний борлуулалтын орлого өссөн нь уламжлалт хэвлэл мэдээллийн сувгийг бэхжүүлэх санаачилгууд үр дүнгээ өгч буйг харуулж байна.
- Контент борлуулалтын орлого **2%-**иар буурсан нь контентын гэрээнээс татгалзаж, редакцын бүтээлүүд дээрээ илүү төвлөрч буйг илтгэнэ.
- **“Бусад”** эх үүсвэрээс олох орлогын эзлэх хувь өссөн нь орлогын суваг төрөлжүүлэх санаачилгуудын үр дүн юм.

Орлогын төрөлжилтөд гарсан дээрх өөрчлөлтүүд нь хөтөлбөрийн хүрээнд тодорхойлсон стратегийн чиглэлийн үр дүнг илэрхийлж байна.

Тусгайлсан сургалт, стратегийн төлөвлөлт, бизнес загварын шинэчлэлээр дамжуулан оролцогч байгууллагууд уламжлалт санхүүжилтийн эх үүсвэрээс хараат байдлаа бууруулж, шинэ орлогын загваруудыг эрэлхийлж эхэлсэн.

Манай хөтөлбөр энэхүү өөрчлөлтөд дараах байдлаар хувь нэмэр оруулжээ.


- **Төрөлжсөн бизнес загварын арга зүйгээр** хангасан нь хувийн хэвшлээс олох болон хэвлэмэл бүтээгдэхүүнээс олох орлогын өсөлтөд нөлөөлсөн
- Оролцогч байгууллагуудын **бие даасан байдлыг нэмэгдүүлж**, төрөөс хамаарах санхүүжилтийн хэмжээг бууруулахад чиглэсэн **стратегийн зөвлөгөө** өгсөн
- Гуравдагч этгээдэд контент борлуулахаас татгалзаж, **редакцын бүтээлээс орлого бий болгох шинэ загварт шилжихэд дэмжлэг** үзүүлсэн

Цаашид оролцогч байгууллагууд **төлбөртэй хэрэглэгчид** болон **дижитал санхүүжилтэд суурилсан** загваруудыг илүү хөгжүүлж, **урт хугацааны тогтвортой байдлаа бататгахаар** ажиллаж байна.

НӨЛӨӨЛӨЛ Байгууллагад

ЦӨМИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

Хөтөлбөр эхэлснээс хойш Олон улсын сангийн зүгээс оролцогч байгууллагуудын **Эдийн засгийн хатын индекс (ERI)**-ийг хагас жил тутам тооцоолж байна.



ERI нь оролцогч байгууллагуудын өгөгдлийг ашиглан бизнесийн одоогийн төлөв байдал, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох 7 үндсэн хүчин зүйл дээр суурилсан тогтвортой байдлын оноог гаргадаг шинэ үзүүлэлт юм.

Сүүлийн нэг жилийн хугацаанд оролцогчдын дундаж орлого **46%**-иар нэмэгдэж, медиан өсөлт **44.5%**-тай гарсан нь орлогын төрөлжилтийн стратеги, санхүүгийн мэргэжлийн зөвлөх үйлчилгээний үр дүнг илтгэж байна.

Үүний зэрэгцээ, уншигчдын тоо **22%**-иар нэмэгдэж, медиан өсөлт **20%**-тай байгаагаас харахад редакцын стратеги сайжирч, дижитал өөрчлөлт хурдасч, өгөгдөлд суурилсан контентын хандлага өргөжиж буй нь тодорхой байна.

Онцлох өөрчлөлтүүдийн нэг нь ажиллах хүчний өсөлт бөгөөд дунджаар **27%**-иар нэмэгдсэн боловч медиан өсөлт **10%**-тай байгаа нь зарим байгууллага багийн бүрэлдэхүүнээ мэдэгдэхүйц тэлсэн бол, бусад нь үйл ажиллагааны үр ашигт анхаарсан болохыг харуулжээ.

Эдгээрээс Монголын бие даасан хэвлэл мэдээллийн салбарт санхүүгийн тогтвортой байдал бэхжиж, олон нийтэд хүрэх хүртээмж өргөжих тодорхой хандлага харагдаж байна.

Хөтөлбөрийн гол дэмжлэгүүдээс гадна бид оролцогч **байгууллага хоорондын хамтын ажиллагааг** дэмжиж, **контент үйлдвэрлэл, орлогын загвар, үзэгчдийн оролцооны сайн туршлага**удаас харилцан суралцах боломжийг бүрдүүлсэн.

Ингэснээр peer-learning буюу хамтын суралцах зарчим нь байгууллагуудыг шинэ орлогын эх үүсвэр болох төлбөртэй уншигч, контентын ивээн тэтгэлэг, олон нийтийн санхүүжилт зэрэг **инновацийг нэвтрүүлэхэд** түлхэц өгчээ.


Мөн, **хүн капиталд төвлөрсөн дэмжлэг** нь ажилчдын тогтвор суурьшил нэмэгдэх, шинэ мэргэжилтнүүд ажилд авахад эерэг нөлөө үзүүлж, байгууллагууд өсөлтөө тогтвортой хадгалахад шаардлагатай хүний нөөцийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэв.

"Өмнө нь бид санхүүгийн сахилга батгүй байлаа. Харин одоо бид урт хугацааны тогтвортой байдлаа төлөвлөх тодорхой орлогын стратегитай болсон."
-Ж.Тэгшжаргал "Gereg & UB.Life" компанийн Гүйцэтгэх Захирал

Санхүүгийн тогтвортой байдал, хүний нөөцийн тэлэлт, үйл ажиллагааны орлогын өсөлт нь Монголын бие даасан хэвлэл мэдээллийн байгууллагуудын хувьд **сайн жишиг** тогтоож байна.

Энэхүү хөтөлбөр нь оролцогч байгууллагууд **амь зуух стратегиас ангижирч, өсөлтөд чиглэсэн бодлогыг бий болгож**, зөвхөн санхүүгийн хувьд тогтвортой төдийгүй ирээдүйд **өөрсдийн нөлөөллийг хадгалах стратегийн бэлтгэлтэй болох** суурийг тавьжээ.

БАЙГУУЛЛАГА ТУС БҮРИЙН ОРЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ, СҮҮЛИЙН 5 ЖИЛЭЭР (ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ОРУУЛААГҮЙ) (ТУС БҮРИЙН СҮҮЛИЙН БАГАНА 2024 ОНЫ ОРЛОГЫГ ТӨЛӨӨЛӨВ)



МЕМО2024: “IFRIM МОНГОЛ”
ХӨТӨЛБӨРИЙН НЭЭЛТ
2024.11.21



НӨЛӨӨЛӨЛ Редакцад

СЭТГҮҮЛ ЗҮЙГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ

Хөтөлбөр хэрэгжихээс өмнө оролцогч редакцууд тогтворгүй стратеги, хоцрогдсон бүтэц, гүнзгий эрэн сурвалжилга хийх бололцоо дутмаг байх зэрэг олон асуудалтай тулгарч байв. Хөтөлбөрийн хүрээнд олгосон сургалт, бүтцийн шинэчлэл, редакцын хараат бус байдлыг бэхжүүлэх дэмжлэг нь оролцогчдыг сэтгүүл зүйн стандартаа сайжруулж, эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чадавхаа дээшлүүлж, уншигчдын мэдэх эрхийг хангах нөлөө бүхий контент бүтээхэд түлхэц өгч байна.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүйг дэмжиж, сайн сурвалжилга бэлтгэх нь

- Оролцогч байгууллагууд засаглалын ил тод, хариуцлагатай байдал зэрэг нийтийн эрх ашигт хамаарах сэдвүүдэд төвлөрөх замаар эрэн сурвалжлах бүтээлийн гарцаа нэмэгдүүлж байна.
 - **iToim** аналитик нийтлэлийнхээ тоог **гурав дахин** нэмэгдүүлсэн. Үзэгчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс **“Шүгэл үлээгч”** буланд ирсэн уншигчдын хүсэлтийг тогтмол хянаж, мэдээлэлд үндэслэсэн сурвалжилгууд бэлтгэх ажлыг идэвхтэй хэрэгжүүлж байна.
 - **Graph.mn** нийгмийн сүлжээний платформд мэдээллийн **шууд дамжуулалт, дижитал мэдээний шинэ хэлбэр нэвтрүүлсэн**. Уншигчдын эрэлт хэрэгцээнд уялдуулан Instagram сувгаа нээж, **уншигчидтайгаа илүү идэвхтэй харилцаа** тогтоосон.
 - **UB.Life** дижитал контент бүтээх ажлаа өргөжүүлж, ялангуяа **богино хэмжээний видео контент** бүтээх замаар залуу уншигчдыг татах стратеги хэрэгжүүлж байна. Тэд **засаглал, хүйсийн тэгш байдал, мэдээллийн боловсрол** зэрэг нийгмийн чухал сэдвийг агуулгадаа түлхүү тусгах чиглэлээр ажиллаж байна.
 - **Lemon Press** эдийн засаг, санхүүгийн салбараар дагнан нийтэлдэг хэдий ч томоохон үйл явдлын үеэр (жишээ нь, 2024 оны сонгууль) редакцын бодлогоо тэлж, үзэгчдэд зайлшгүй чухал мэдээ мэдээллийг хүргэх чиглэлээр бусад сэдвүүдийг ч хөндөн ажиллаж байна.

Редакцын чадавхыг бэхжүүлж, нийгэмд илүү нөлөөтэй контент бүтээх нь

- **Зууны Мэдээ** редакцдаа **хагас жил тутамд эрэн сурвалжлах нийтлэлийн уралдаан** зохион байгуулж, сэтгүүлчдийг идэвхжүүлж, салбарын түвшинд **шинэ жишиг** тогтоож байна. Тэд уралдааны шүүлтийн багтаа бусад **хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл, их сургуулийн багш, оюутнуудыг** урьж оролцуулдаг.
- **NTV** мэдээний автоматжуулалтын систем нэвтрүүлснээр илүү даацтай сэдвүүдэд төвлөрч, сурвалжлагчдаа урьдчилан тодорхойлсон сэдвүүд дээр ажиллуулах боломжийг бүрдүүлж, **нийгэмд бодит өөрчлөлт авчрах** чиглэлд анхаарч байна.



НӨЛӨӨЛӨЛ Редакцад

СЭТГҮҮЛ ЗҮЙГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ




Өгөгдөлд суурилсан редакцын стратеги

iToim манай хөтөлбөрийг редакцын төлөвлөлтийг илүү оновчилсон гэж үнэлжээ. Тэд Agile менежментийн системийг нэвтрүүлж, редакцын үр ашигтай байдлаа сайжруулсан. Үүн дээрээ нэмэлтээр, сэтгүүлчдийн цалингийн урамшуулал бүхий гүйцэтгэлийн үнэлгээний системийг бий болгожээ.



Технологи суурьт интерактив сэтгүүл зүй

Graph.mn дүрстэй контент, шууд дамжуулалт хийдэг болсноор дижитал хэрэглэгчидтэйгээ илүү ойртож, тэдний мэдээллийн боловсролд түлхүү анхаарч байна.



Уншигчдад нээлттэй, ил тод сэтгүүл зүй

Зууны Мэдээ редакцын аналитик бүтцэд шилжиж, үзэгчдийн өгөгдөлд тулгуурлан нөлөө бүхий контентуудад төвлөрч байна. Тэд контентын нөлөөг хянах хоёр долоо хоног тутмын хурал хийж, редакцын богино хугацааны стратегиа уян хатан болгосон.



Мөн Зууны Мэдээ нь **JTI (Journalism Trust Initiative) батламжийг** авсан Монголын анхны хэвлэл мэдээллийн байгууллага болж, шинэ түвшний ил тод байдлын стандарт тогтоолоо.


НӨЛӨӨЛӨЛ Нийгэмд

ӨӨРЧЛӨЛТӨД ХӨТЛӨХ НЬ

Хөтөлбөрийн нөлөөлөл нь зөвхөн оролцогчдоор хязгаарлагдахгүй. Учир нь хэвлэл мэдээллийн байгууллагууд **олон нийтийн хэлэлцүүлэг, иргэдийн оролцоог бэхжүүлж, бодлого боловсруулах үйл явцад** чухал нөлөөтэй. Судалгаа, шинжилгээтэй сэтгүүл зүйгээр дамжуулан дижитал үзэгчдийн оролцоог нэмэгдүүлснээр оролцогч байгууллагууд **бодлогын мэтгэлцээнд нөлөөлж, уншигчдын итгэлийг нэмэгдүүлжээ.**

NTV-ийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны санхүүжилтийн талаарх тууштай сурвалжилга нь төсөвт тусгалаа олсноор цэцэрлэгийн хоолны санхүүжилт хоёр дахин нэмэгдэв.

2019 оноос хойш цэцэрлэгийн хүүхдийн хоолны төсөв 2,475-3,600 төгрөг байсныг төрөөс нэмэгдүүлэх шийдвэр гаргаж, эцэг эхчүүдээс тодорхой хувийг гаргуулахаар зохицуулжээ.



Үүний үр дүнд хүүхдийн **хоолны шим тэжээл өмнөх жилүүдтэй харьцуулахад сайжирсан.** 2024 оны эцэс гэхэд нэг хүүхдийн хоолны төсөв 4,000-5,100 төгрөг байх төлөвтэй байна. Энэхүү өөрчлөлт нь **264,818 цэцэрлэгийн хүүхдэд** шууд үр өгөөжөө өгөх юм.



Монголын хөрөнгийн зах зээлд ногдол ашгийн төлөлтийн огноо тодорхойгүй байсан нь асуудал байсаар иржээ.


Иймд Lemon Press Улаанбаатарын Хөрөнгийн Биржтэй хамтран **кампанит ажил эхлүүлж**, нээлттэй компаниуд ногдол ашгийнхаа төлбөрийн огноог ил тод, цаг тухайд нь зарлахыг шаардсан.

28 мэргэжилтэн санаачилгыг дэмжиж, ач холбогдлыг онцолсон бол **6 хувьцаат компани (JSC) шинэ стандартыг дагаж мөрдөхөө мэдэгдэж, Монголын компаниудын санхүүгийн ил тод байдлын шинэ жишгийг тогтоожээ.** Энэхүү кампанит ажил нь хөрөнгө оруулагчдад илүү үр дүнтэй санхүүгийн төлөвлөлт хийх боломжийг бүрдүүлж, 2025 онд бодлогын шинэчлэлийн дараагийн шатанд орох суурийг тавьсан. Хөтөлбөрийн үр нөлөөг урт хугацаанд хадгалахын тулд уг санаачилгад одоо ч тогтмол хяналт тавьж байна.

2024 оны Улсын Их Хурлын сонгуульд нийт 19 нам, 2 эвсэл оролцов.

Сонгуульд оролцох намууд болон эвслүүд нь өөрсдийн мөрийн хөтөлбөрийг Үндэсний аудитын газарт хянуулж, батлуулах үүрэгтэй.

Ийнхүү 2024 оны 6-р сарын 10-ны өдөр сонгуульд оролцогчид мөрийн хөтөлбөрөө олон нийтэд нээлттэй зарласан байна.



Иргэдийг мэдээлэлтэй сонголт хийхэд дэмжлэг үзүүлэх үүднээс iToim сонгуульд оролцож буй бүх нам, эвслийн **мөрийн хөтөлбөрийг нэг дороос харьцуулах боломжтой платформ** хөгжүүлжээ. Ингэснээр сонгогчид улс төрийн бодлогыг илүү ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар үнэлэх боломжийг олгосон байна.

НӨЛӨӨЛӨЛ Нийгэмд

ӨӨРЧЛӨЛТӨД ХӨТЛӨХ НЬ

Монголд зөвхөн агаарын бохирдлоос болж жилд 7139 хүн нас барж байна гэнэ үү

Graph
2024-09-20



Агаарын бохирдол бол Улаанбаатар хотод хамгийн тулгамдсан асуудлуудын нэг. Энэ асуудлыг хөндөж **Graph.mn цуврал нийтлэл болон брэнд контент** бэлтгэжээ. Хамгийн нөлөөтэй бүтээл нь "Улаанбаатарын өглөө" хэмээх фото цуврал байсан бөгөөд ердөө хэдхэн зургаар агаарын бохирдлын ноцтой байдлыг харуулжээ.


Энэхүү цуврал контент өргөн хүрээнд түгж, зөвхөн Instagram дээр л гэхэд 617,000 хүнд хүрч, 4,300 удаа хуваалцагдаж, 3,000 гаруй лайк, сэтгэгдэл авсан.

Graph.mn болон **өөр олон хэвлэл мэдээллийн байгууллага энэ асуудлыг онцолж**, улмаар засгийн газраас шат дараалсан арга хэмжээ авчээ.

Зөвхөн Graph.mn уг нөлөөллийг бий болгосон гэх боломжгүй ч **бодлогын өөрчлөлтөд залуусын анхаарлыг татаж, оролцоог нэмэгдүүлэх**эд түүчээлэн ажилласан байна.

Зууны Мэдээ сонин "Улаанбаатар хот үерээс хамгаалагдах уу: Сэлбэ, Дунд голоос 10 км бургас нүүлгэх төлөвлөгөө" нэртэй эрэн сурвалжилга 4-р сарын 10-нд нийтэлсэн. Энэхүү нийтлэлийн дараа уг асуудал **олон нийтийн анхаарлыг татаж**, тодорхой хугацааны дараа албаны байгууллагуудад хүрч эхэлжээ.

Удаагаар нь 6-р сарын 26-ны дугаарт "Бургас нүүлгэх ажил удааширвал Улаанбаатар үерт автана" давтан нийтэлсэн байна.



Үүнээс хойш, бургас нүүлгэх ажил эрчимжсэн бөгөөд энэхүү нийтлэл нь Зууны мэдээ сонины 2024 оны 24 эрэн сурвалжлах бүтээлийн нэг байсан юм. Салбарын мэргэжилтнүүд уг нийтлэлийг өндөр үнэлж, Зууны мэдээ сонин Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлээс **"Оны шилдэг сонин"** шагналыг хүртжээ.

"Баавгай болохсон" киног Оскарын шалгаруултад нэр дэвшүүлэхээр болжээ

О.АНХЗАЯА 2024.09.27



Монгол Улсаас Оскарт бүтээл тодорхойлох маргаан анх "Баавгай болохсон" киноны найруулагч П. Золжаргалын мэдэгдлээр олон нийтэд ил болсон. Түүний байр суурийн дараа **UB.Life**-ийн сэтгүүлчид энэ асуудлаар цуврал ярилцлага, тайлбар нийтлэн, нэр дэвшүүлэх үйл явц ил тод бус байгаа талаар хөнджээ.

Зөвхөн **UB.Life** төдийгүй бусад хэвлэл мэдээллийн хэрэгслүүд уг асуудлыг өргөн хүрээнд мэдээлсний үр дүнд Соёлын яам 2-3 долоо хоногийн дотор нэр дэвшүүлэх шийдвэрээ эргэн харж, өөрчилсөн байна. Үүний дараа найруулагч **UB.Life** редакцад зочилж, асуудлыг **олон нийтэд мэдээлж, хариуцлага тооцуулах**ад оруулсан хувь нэмрийнх нь төлөө талархал илэрхийлжээ.



**“IFPM МОНГОЛ” ХӨТӨЛБӨРИЙН 2024 ОНЫ НӨЛӨӨЛЛИЙН ТАЙЛАН
СЭТГҮҮЛ ЗҮЙН ИННОВАЦ, ХӨГЖЛИЙН ҮҮР ТӨВ НҮТББ**

WWW.NESTMONGOLIA.ORG
HELLO@NESTMONGOLIA.ORG

+976 77116569 /ОФФИСЫН ШУГАМ/
+976 86201699 /ХӨТӨЛБӨРИЙН МЕНЕЖЕР/

УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС